| 3.14 | Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын явцад холбогдох хотын стандартын шаардлагыг хангуулах, хяналт тавьж стандартыг мөрдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 85% | 100% | Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 520 хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудад холбогдох стандарт, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 хувь |
| 3.15 | Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих тохижилт, бүтээн байгуулалтын ажилд агаарын харьцангуй чийгшлийг нэмэгдүүлэх ногоон байгууламжийн төрлийг нэмэгдүүлэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг техник технологийн тоног төхөөрөмжөөр тоноглох арга хэмжээг авч ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламжийн ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 2, 10, 27 дугаар хороодын нутаг дэвсгэрт Шинээр байгуулах цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд нийт 30,500 м.кв зүлэгжүүлэлт, 13,500 ширхэг мод бут сөөг шинээр тарьж, талбайн арчилгаа тогтмол хийж байна. | 100 хувь |
| 3.16 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт захирамжаар эрх шилжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны бэлтгэлийг хангаж зургийн даалгавар боловсруулж, газрын асуудлыг судлан ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 94.3% | 100% | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллаагааны бэлтгэлийг хангаж ажилласан. | 100 хувь |
| 3.17 | Насжилт урттай хийц дизайн өвөрмөц материал ашиглан | - | Үйл ажиллагааны | 100% | 100% | Улаанбаатар хотын Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Их, бага тойруу, | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | одоо байгаа явган замыг шинээр мөрдөгдөх стандартын дагуу гүйцэтгүүлэх | | хэрэгжилт, хувь | | | Олимпын гудамж, Их Монгол Улсын гудамжуудыг хамруулан нийт 15 байршилд явган замын хуучин шахмал хавтанг хуулж шинээр 100 жилийн насжилттай байгалийн боржин чулуун хавтангаар 186.000м2 зам талбайг хучих ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Дээрх ажлуудын зураг төсөлд хот тосгоны төлөвлөлт, явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, явган хүний зам талбайн төлөвлөлт, хучилтын стандартыг тусгаж баталсанаар гүйцэтгүүлэх бөгөөд одоогийн байдлаар 9-н байршилд тохижилтын ажил эхлээд байна. | |
| 3.18 | Хотын хөгжлийн индексийн хүрээнд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөн гүйцэтгүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Нийслэлийн засаг даргын 2024 оны А/1131, А/1203, А/1204, 2025 оны А/21, А/109, А/703 дугаартай захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын Сүхбаатарын талбай орчим, Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Их, бага тойруут, Олимпын гудамж, Их Монгол Улсын гудамж дагуу явган хүний хуучин хавтанг буулгаж шинээр 180 мянган м2 талбайг боржин чулуун хавтангаар хучих ажил хийгдэхээр төлөвлөсөн. Өнөөдрийн байдлаар Энхтайваны өргөн чөлөөний зам дагуу 3500 м2 талбайг хучиж дуусгаад байна. | 100 хувь |
| 3.19 | “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангуулж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газрын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/2080 дугаар албан бичгийн хүрээнд “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах” тухай 67 төсөл арга хэмжээний, 67 гүйцэтгэгч компанид орчны болон ажилчдын амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж ажилласан. | 100 хувь |
| 3.20 | Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газрын засаглалыг сайжруулан 2024 онд Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015, Төслийн менежментийн арга зүйн заавар MNS ISO 21500:2017 стандартыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн | 85 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Барилгын чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах | | | | | ажиллаж байна. Тус стандартыг хэрэгжүүлэн ажилласнаар Газрын үйл ажиллагааг тасралтгүй явуулах чанарыг сайжруулах, цаашид хэвшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж холбогдох сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж 55 албан хаагчийг хамруулав.<br>Газрын даргын тушаал 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/36 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015, Төслийн менежментийн арга зүйн заавар MNS ISO 21500:2017 стандартыг 2025-2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Барилга угсралтын технологийн хугацаа эхэлсэнтэй холбогдуулан гүйцэтгэгч байгууллагуудтай нэгдсэн уулзалтыг 6 дугаар сард багтаан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| 3.21 | Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцыг сурталчлах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Газрын 2025 оны "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр газрын даргаар батлуулав.<br>Тус төлөвлөгөөнд нийт хяналтын инженерүүдийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. | 80 хувь |
| 3.22 | Үйлдвэрлэлийн ослыг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулах | - | Зохион байгуулсан ажлын тоо | 100% | 100% | Барилга угсралтын ажил эхэлж байгаатай холбогдуулан гүйцэтгэгч компаниудад "Үйлдвэрлэлийн ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах" тухай сурталчлах, мэдлэг олгох сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 70 хувь |
| 3.23 | Хяналт шалгалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 85% | 100% | Хяналт шалгалттай холбоотой Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт Хяналт шалгалт хийх нийтлэг журам, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/96 дугаартай тушаалын хавсралт "Дотоод хяналтыг зохион байгуулах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 хувь |
| Хуулиар олгосон чиг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилт, хувь | | | | | | | **96.5 хувь** |
| Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 4. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгох | | | | | | | |
| 4.1 | Газрын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, хагас, бүтэн жилээр үр дүнг нэгтгэн тайлагнаж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90% | 100% | Газрын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг улирал бүр авч, үр дүнг нэгтгэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 37 гүйцэтгэгчээс судалгаа авсан бөгөөд судалгаанд оролцогчдын олонх нь сэтгэл ханамж сайн гэсэн үнэлгээг өгсөн ба хариу арга хэмжээ авах шаардлагатай гомдол санал ирээгүй. | 100 хувь |
| 4.2 | Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | 2024 онд НХОГазар захиалагчийн хяналт тавин хэрэгжүүлсэн 638 төсөл арга хэмжээнээс 410.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 214 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна. 2024 онд бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн товч танилцуулгыг Нийслэлийн 9 дүүргээр бэлтгэж, НИТХ-ын 45 төлөөлөгчдөд 2025 оны 05 дугаар 23-ны өдрийн 01/2044 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100 хувь |
| 4.3 | Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээллийг өдөрт нь багтаан хүлээн авч ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | "Хороо бүртгэсэн" системээр манай газарт 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр № H2505090002 дугаартай иргэн О.Алтангэрэлээс ирүүлсэн хүсэлтийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Барилгын хяналтын инженер Х.Орхонсэлэнгэ мэдээллийг өгч, албан бичгээр шийдвэрлэн ажиллав. | 100 хувь |
| 4.4 | Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, | - | Үйл ажиллагааны | 90% | 100% | Тайлант хугацаанд төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэхэд | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах | | хэрэгжилт, хувь | | | гарсан хүндрэл бэрхшээл, гомдол гараагүй. Гүйцэтгэгч байгууллагуудад тухай бүр түргэн шуурхай үйлчилж байна.<br>Газрын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр тогтмол санал асуулга авч ажиллаж байна. | |
| 4.5 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 94% | 100% | 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Erp.Ulaanbaatar.mn өргөдөл, гомдлын программд нийт 55 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд: иргэнээс 44, албан хаагчаас 11 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба хугацаандаа шийдвэрлэгдсэн 50 буюу 90 хувь, судлагдаж байгаа 5 буюу 6 хувь өргөдөл, гомдол байна.<br>Тайлант хугацаанд өдөрт нь багтаан шилжүүлээгүй 2 зөрчил бүртгэгдсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 23 цаг 40 минут байна.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах ажлын хүрээнд "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын 2025 оны өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Өргөдөл, гомдлын 1 дүгээр улирлын тайланг, өргөдөл гомдлыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хамт даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр албажуулан, 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/1203 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэн ажиллав. | 90 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хагас жилийн байдлаар 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | |
| 4.6 | Нийслэлийн Засаг дарга, Газрын даргаас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр бүх шатны шүүх, хуулийн байгууллагад төлөөлөх, эрх бүхий байгууллагын шийдвэрийг тухай бүр танилцуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | 2025 оны хагас жилийн байдлаар Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шатанд 12 хэрэг маргаан байна. Үүнээс эцэслэн шийдвэрлэгдсэн захиргааны хэрэг-2, иргэний хэрэг 2 байна. Шүүхийн шатанд байгаа хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан нийт 20 удаа шүүх хуралд оролцсон байна. | 100 хувь |
| 4.7 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 03/2113 бичгийн хэрэгжилтийн хүрээнд Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулан ажилласан.<br>Тус ажлын хэсэг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.1, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 5 дугаар бүлгийн 335 дугаар зүйлд тусгагдсан арга хэмжээ, Газрын дотоод засаглалын төлөв байдлын дүн шинжилгээ хийсэн тухай тайлан, хавсралт 259 хуудас материалыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1656 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 100 хувь |
| 4.8 | Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Тус арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах тухай Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас холбогдох байгууллагуудад нэгдсэн чиглэл ирүүлнэ гэв. Чиглэл ирсний дараа Газрын даргын тушаалаар төлөвлөгөө батлуулан ажиллахаар хүлээгдэж байна.<br>Хяналт, мониторинг чиглэлээр дараах ажлыг хэрэгжүүлэхээр дотоод зохион байгуулалтыг ханган ажиллаж байна.<br>Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Хяналт-шинжилгээ, | 90 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээний хорооны 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж, 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр газрын даргад тайлагнан ажиллахаар төлөвлөж байна. | |
| 4.9 | Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Манай газар нь Улс, Нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн болон бусад хөрөнгө оруулалтаар барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг мэргэжлийн байгууллага юм.<br>Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны даргын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Судалгааны баримт бичгийн стандартчилал батлах тухай" А/85 дугаар тушаалыг хэрэгжүүлэн газрын чиг үүргийн хүрээнд албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн маягтыг боловсруулах ажлыг эхлүүлэв. Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг "Баримт бичиг-Статистикийн мэдээллийн маягтын" дагуу гарган ажиллаж байна. | 100 хувь |
| 4.10 | Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсуулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллах эхлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/62 дугаар тушаалаар "Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг"-ийг 9 гишүүнтэй байгуулагдсан.<br>Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байна. | 70 хувь |
| Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хэрэгжилт, хувь | | | | | | | **95 хувь** |
| Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 5 | | | | | | | |
| 5.1 | "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг төлөвлөгөө гарган заалт тус бүрээр ажил, арга хэмжээ зохион байгуулах | - | Төлөвлөгөө-ний хэрэгжилт, хувь | - | 100% | Газрын даргаар 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоол "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 80 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон хэлтсийн даргад тайлагнан ажиллана. | |
| 5.2 | Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор бүтээсэн үндэсний контентыг бүтээж, түгээх ажлыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан ажлын тоо | - | 100% | Газрын цахим хуудсаар "Авлигын эсрэг нэгдье", "Авлигад Үгүй гэж хэлье", "Авлигыг тасалъя", "Авлигыг мэдээлэх утас 110", "Авлигын эсрэг нэгдэх өдөр" сэдэвт **8** уриалга постеруудыг албан хаагчид болон олон нийтэд сурталчилж ажиллав. Мөн invest.ub.gov.mn вэб хуудаст "Авлигын эсрэг шинэтгэл" булан ажиллуулж "Авлигын эсрэг нэгдье" сэдэвт **8** постеруудыг нийтлэн түгээж ажиллав. | 100 хувь |
| 5.3 | Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Газрын нүүрном хуудас болон invest.ub.gov.mn вэб хуудас, erp.ulaanbaatar.mn системүүдээр дамжуулан "Авлигыг мэдээлэх утас 110", "Авлигын эсрэг нэгдье" сэдэвт уриалгуудыг түгээж байна. | 100 хувь |
| 5.4 | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах | - | Сурталчил-сан тоо | - | 100% | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор Газрын нүүрномын хуудсаар "Авлигын эсрэг нэгдье", "Авлигад Үгүй гэж хэлье", "Авлигыг тасалъя" сэдэвт **8** уриалга постер, Erp.ulaanbaatar.mn системд "Авлигыг мэдээлэх утас 110", "Авлигын эсрэг нэгдэх өдөр" сэдэвт **2** уриалга постеруудыг албан хаагчид болон олон нийтэд сурталчилж ажиллав. Мөн invest.ub.gov.mn вэб хуудаст "Авлигын эсрэг шинэтгэл" булан ажиллуулж "Авлигын эсрэг нэгдье" сэдэвт **8** постеруудыг нийтлэн түгээж ажиллав. | 100 хувь |
| 5.5 | Хувийн ашиг сонирхлын нөхцөл үүсэж болзошгүй, үүсгэх нөхцөл байдал үүсгэсэн буюу аливаа хэлбэрээр шийдвэрт нөлөөлөхийг оролдсон тохиолдол бүрийг мэдэгдэж хэвших | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Тайлант хугацаанд хувийн ашиг сонирхлын нөхцөл үүсэж болзошгүй, үүсгэх нөхцөл байдал үүсгэсэн буюу аливаа хэлбэрээр шийдвэрт нөлөөлөхийг оролцсон тохиолдол гараагүй байна.<br>Цаашид дээрх нөхцөл байдал үүссэн тохиолдолд хуулийн хүрээнд холбогдох албан тушаалтанд мэдэгдэх үүргийг хэрэгжүүлэн, хэвшүүлж ажиллана. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Газрын даргын Үнэлгээний хороо байгуулах тухай тушаалын хүрээнд нарийн бичгийн дарга нарт хувийн ашиг сонирхлын нөхцөл үүсэж болзошгүй, үүсгэх нөхцөл байдал үүсгэсэн буюу аливаа хэлбэрээр шийдвэрт нөлөөлөх тохиолдолд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Нийтийн албан тушаалтны ашиг, сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллах тухай чиглэл өгч ажиллав. | |
| 5.6 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн чиглэлийн дагуу газрын хэмжээнд хийж хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг бүрэн хангах | - | Төлөвлөгөө-ний хэрэгжилт | - | 100% | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 03/3735 дугаартай албан бичгээр ирүүлсэн нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөө"-г манай газарт ирүүлсэн.<br>Тус төлөвлөгөөний хүрээнд "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Холбогдох биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 90 хувь |
| 5.7 | Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг газрын даргаар 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Төлөвлөгөөний хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд арга хэмжээг 2025 оны 07 дугаар сард зохион байгуулж ажиллана. | 95 хувь |
| 5.8 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн | - | Үйл ажиллагааны | - | 100% | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн | 80 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлийн хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ | | хэрэгжилт, хувь | | | 03/3735 дугаартай албан бичгээр ирүүлсэн төлөвлөгөөний дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 6 зорилго, 18 арга хэмжээг газрын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн бөгөөд биелэлтийг холбогдох хэлтэстэй хамтран гаргаж 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилт, хувь | | | | | | | **93 хувь** |
| Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх 6. | | | | | | | |
| 6.1 | Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаалаар батлагдсан хөдөлмөрийн "дотоод журам", 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан "Ажилтны Ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, ажлын сахилга хариуцлага алдаж холбогдох хууль, журмын дагуу албан тушаалтанд хариуцлага тооцох нөхцөл байдал үүсээгүй байна.<br>Газрын Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулсан. "Ёс зүйн дэд хороо" болон "Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээллийг шийдвэрлэх" ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын "Хайрцаг"-ийг Газрын мэдээллийн самбар болон дотоод сүлжээнд байршуулан, ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэв. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар ёс зүйн зөрчил, гомдол мэдээлэл ирээгүй байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн 2025 оны 03 дугаар сарын 17-21-ний өдрийг дуустал хугацаанд албан хаагчдын ёс зүй, ёс суртахууны тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой "ЁС ЗҮЙТЭЙ АЛБАН ХААГЧ" үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын талаар нийт 6 удаагийн постер мэдээллийг бэлтгэн дотоод сүлжээнд байршуулан мэдээлэл өгөв.<br>Албан хаагчид сахилга хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх хүрээнд дараах сургалтад хамрагдав. Үүнд:<br>✓ Газрын "Ёс зүйн дэд хороон"-оос "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж 48 албан хаагч,<br>✓ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх" сургалтад 3 албан хаагч тус тус хамрагдав. | |
| 6.2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын Ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг хангаи ажиллаж, төлөвлөгөөний биелэлт хагас жилийн байдлаар 88,6 хувьтай хэрэгжив. "Ёс зүйн дэд хороо" болон Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын "Хайрцаг"-ийг Газрын мэдээллийн самбар болон дотоод сүлжээнд байршуулан, ажилтан, албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Одоогоор ёс зүйн зөрчил, гомдол мэдээлэл ирээгүй байна.<br>Мөн "Ёс зүйн дэд хороо"-ны төлөвлөгөөний дагуу 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрийг дуустал хугацаанд албан хаагчдын ёс зүй, ёс суртахууны тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой "ЁС ЗҮЙТЭЙ АЛБАН ХААГЧ" үйл ажиллагааг зохион байгуулж "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Газрын ёс зүйн дүрэм", Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)", Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/62 дугаар захирамж, Академич, доктор профессор, хуульч С.Нарангэрэлийн "Ёс суртахуун, ёс зүйн" талаар өгсөн мэдээллийг постер байдлаар бэлтгэн дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад мэдээлэл хүргэсэн.<br>2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтыг Хууль зүйн доктор, судлаач багш Л.Мөнх-Эрдэнэ удирдан явуулж, ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт болон холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчдын нийтлэг гаргаж буй алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх практик, жишээг дурдан мэдлэг мэдээлэл өгч, сургалтад нийт 48 ажилтан, албан хаагч хамрагдсан.<br>Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03/2617 дугаарын албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны харьяа байгууллагын нийт албан хаагч нарт холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Ажлын байранд ёс зүйн хэм, хэмжээг мөрдөж ажиллахыг анхааруулсан тухай мэдэгдлийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотоод сүлжээнд байршуулан нийт албан хаагч нарт мэдээллийг хүргэж ажилласан. | |
| 6.3 | Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 100% | Газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж буй ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны болон Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг Газрын цахим хуудас, сайтад тухай бүр илт тод байршуулан ажиллаж байна. | 100 хувь |
| Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилт, хувь | | | | | | | **100 хувь** |
| **ДУНДАЖ ХУВЬ** | | | | | | | **96.3 хувь** |

*Төлөвлөгөөг хянасан:*
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ: ................................................... (Х.НЯМБААТАР) ...................................
*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:*
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА: ................................................................................ (Б.МӨНХБАТ) 2025.06.13
*(огноо)*